


목록

240408-홍역 예방수칙_몽골어	1
240408-홍역 예방수칙_몽골어2	2
240408-홍역 예방수칙_몽골어3	3
240408-홍역 예방수칙_몽골어4	4
240408-홍역 예방수칙_몽골어5	5
240408-홍역 예방수칙_몽골어6	6
240408-홍역 예방수칙_몽골어7	7



Та гадаадад зорчих бэлтгэлээ хийж байна уу?

Улаан Бурхан Өвчинөөсурьдчилан сөргийлэх заавар Улаан Бурхан өвчинөөсурьдчилан сөргийлье!



⊕ Улаанбурхан өвчний тодорхойлолт ба шинж тэмдэг ⊕

**Ханиалгах эсвэл нийтаах үед агаар дуслын замаар
тархаж халдварладаг,
халдварлалт өндөртэй цочмог халдварт өвчин юм.**

※ Улаанбурхны дархлаа султай хүн өвчтөнтэй хавьтсан тохиолдолд,
90% ээс дээш хувь нь халдвар авах боломжтой.

⊕ Улаанбурхан өвчний илрэх шинж тэмдэг ⊕

(нууц үе 7~21 хоног)

Улайх үрэвслийн үе

Тууралтын үе

Эдгэрэлтийн үе



Халдварлалт өндөр үе ба цочмог халуурах, ханиалгах, нусгоожих, нүдний салст бүрхэвч үрэвсэх, амны салстад толбо үүснэ.



Хүзүүний ар тал, чихний доод, их бие, гар хөл, гарын алга хөлний ул-хэсэгт гүвдруүт улаан өнгөтэй тууралт гарна.



Тууралт арилж нөсөө толбо үлдэнэ.


※ Гуурсан хоолойн үрэвсэл, уушигны хатгалгаа, круп зэрэг амьсгалын замын үрэвсэл, сууулгалт, тархи нугасны үрэвсэл зэрэг хүндрэл үүснэ.

⊕ Улаанбурхан өвчний дэгдэлтэй улс орон ⊕

**Дэлхий даяар улаанбурхан өвчний тохиолдол ихсэж*
байгаа ба гадаадад зорчих иргэд ихэссэнтэй
холбоотойгоор улаанбурхан өвчнөөр өвчлөх
магадлал нэмэгдэж байна.**


⊕ Улаанбурхан өвчний өвчлөлийн бүс нутгийн тархалт ⊕

Европ, Ойрхи Дорнод, Зүүн өмнө Азийн орнуудад үе үе дэгдэлт,
тархалт үргэлжилсээр байна.



* 2023 онд дэлхийн хэмжээнд улаанбурхан өвчний өвчлөл ойролцоогоор 300,000 тохиолдол бүртгэгдсэн
(ДЭМБын үзүүлэлтээр 22оноос 1.8 дахин их)

Гадаадад зорчигч нарт зориулсан улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар



Аялалын өмнө

- ✓ Улаанбурханаас сэргийлэх вакцин(MMR) 2 удаа хийлгэсэн эсэхээ шалгах
- ✓ Хэрэв та 2 удаа хийлгээгүй, вакцин хийлгэсэн эсэхдээ эргэлзэж байвал, гадаад орон руу явахаас 28~42 хоногийн өмнө, эмнэлэгт хандан, вакцинаа 28 хоногийн зйтай 2 удаа хийлгэх



Аялах хугацаанд

- ✓ Хүн ихтэй газар амны хаалт зүүх, гарaa угаах, ханиалгахдаа хувийн эрүүл ахуйн дүрэм журмыг дагаж мөрдөх



Хилээр нэвтрэх үе

- ✓ Хилээр орж ирэхдээ халуурах эсвэл тууралт гарсан тохиолдолд, хорио цээрийн албаны ажилтанд мэдэгдэх


Хилээр нэвтэрсний дараа халуурах, тууралт зэрэг сэжигтэй шинж тэмдэг илэрвэл



Амны хаалт зүүж аль болох бусадтай харилцах харилцааг багасгаж,
эмнэлэгийн байгууллагад хандах
(Нийтийн тээврээр зорчихгүй байх)



Эмнэлэгийн ажилтанд 'Гадаадад зорчсон тухай' мэдэгдэх



⊕ Улаанбурхан өвчний эсрэг вакцинжуулалтын тухай ⊕

⊕ Улаанбурхан вакцинжуулалтын товлолын насын ангилал ⊕

Насны ангилал	Вакцинжуулалтын арга
Төрснөөс хойш 0~5сар	Вакцинд хамрагдахгүй
Төрснөөс хойш 6~11сар (түргэвчилсэн вакцинжуулалт*) * Вакцинжуулалтын товлолыг мөрдөх боломжгүй үедээ, дархлаажуулалт хурдан авах шаардлагатай үед хийлгэх	Гадаадад зорчихдоо 1удаагийн вакцинжуулалт * 12сартайгаас өмнө хийлгэсэн MMR вакцин нь вакцинжуулалтын тоонд орохгүй тул, цаашид вакцинжуулалтын товлолын дагуу 2 удаа хийлгэх хэрэгтэй
Төрснөөс хойш 12~15сар (товлолын дагуу вакцин хийлгэх)	1 удаа хийлгэх
4~6 нас (товлолын дагуу вакцин хийлгэх)	2 удаа хийлгэх
Өсвөр насынхан болон насандаа хүрэгчид*	※ Дархлааны баталгаа байхгүй тохиолдолд 28 хоногийн зйтэй 2 удаа(доод тал нь 1 удаа) вакцин хийлгэх

* 1968оны 1сар 1нээс өмнө төрсөн бол, улаанбурхан өвчний эсрэг байгаалийн дархлаатай гэж үздэг тул вакцин хийлгэх шаардлагагүй.

※ Улаанбурхан өвчний дархлааны баталгаа байхгүй тохиолдол

Вакцинд хамрагдсан тухай бүртгэлгүй,
улаанбурханаар өвчилж байгаагүй болон улаанбурханы эсрэг биетүүд илрээгүй 1968оны 1сарын 1нээс хойш төрсөн хүмүүс



Гадаадад зорчихоос өмнө улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх заавартай танилцаж, тав тухтай сайхан аялаарай!

